

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.11.03

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 10 дугаар сард 1 удаа хуралдаж 9 тогтоол баталлаа. Үүнд:

1.Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай асуудлыг хэлэлцээд 8 зорилтын хүрээнд нийт 192 арга хэмжээтэйгээр баталлаа.

2.Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлав.

3.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Шаамар сумын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг 2024 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

4.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Цагааннуур сумын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг 2024 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

5.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Баруунбүрэн сумын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг 2024 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

6.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Мандал сумын үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг 2024 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

7.Зөвшөөрлийн хугацаа сунгах тухай асуудлыг хэлэлцээд Сүхбаатар суманд шашны үйл ажиллагаа явуулж байгаа “Төгс баясгалант номын хүрд” хийдийн үйл ажиллагаа явуулах хугацааг 3 жилээр сунган тогтоолоо.

8.Зөвшөөрлийн хугацаа сунгах тухай асуудлыг хэлэлцээд Мандал суманд шашны үйл ажиллагаа явуулж байгаа “Хожмын үеийн гэгээнтнүүдийн Зүүнхараа цуглаан” сүмийн үйл ажиллагаа явуулах хугацааг 3 жилээр сунган тогтоолоо.

9.Ажлын хэсэг байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг Гацуурт ХХК болон тус компанийн хамаарал бүхий бусад аж ахуйн нэгжүүдийн газар эзэмшилт, ашиглалтын байдалтай танилцаж, санал дүгнэлт гарган аймгийн ИТХ-д танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, бүрэлдэхүүнийг баталлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймаг нь “АДРА Монгол” Олон Улсын байгууллагатай ХАА-н салбарт амжилттай хамтран ажиллаж байгаа 13 сум, 30 гаруй хоршоодыг хамруулсан “Органик хөдөө аж ахуйн түншлэл” II төслийг 2023 оны 10 дугаар сарын 01-ээс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

Бичил уурхайгаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх сөрөг талуудыг бууруулах, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд тулгарч буй

бэрхшээл, өнөөгийн байдал, албажуулалтын үйл явц, бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээн дэх эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцогч талууд дүгнэн хэлэлцэх, зөвлөмж гарган холбогдох талуудад хүргүүлэх зорилгоор “Бичил уурхайн бүсийн зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга ОХУ-ын БНБУ-ын Хиагтын районд албан айлчлал хийж Хиагтын сургуульд сурч байгаа хүүхдүүдийг тээвэрлэх автобусны асуудлыг шийдвэрлэг 2024 оны 1-р сараас явуулж эхлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна. ОХУ-ын БНБУ-ын Хиагтын районы ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 1-8 дугаар ангид Сэлэнгэ аймгийн 22 хүүхэд суралцаж байна.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын санаачилгаар ЭМЯ-тай хамтран БНСУ-ын Жинжүгийн эрүүл мэндийн их сургуульд сувилагч нараа сургаж мэргэшүүлэх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэх талууд гурвалсан гэрээг үзэглэлээ.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар Сэлэнгэ аймгийн ЕБС-ын сурагчдын дунд “Super Science Selenge 2023” бүтээлийн уралдааныг зохион байгууллаа. Шинжлэх ухааны туршилт бүтээлийн уралдаанд Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 350 гаруй багш, сурагч хими, физик, байгалийн ухааны хичээлээр олж авсан мэдлэгээ ашиглан шинэ бүтээлүүдээр өрсөлдөж, харилцан туршлага солилцож амжилттай оролцлоо.

10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд “Сэлэнгэ-2023” ширээний теннисний 21 аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Спортын мастер, дасгалжуулагч багш Н.Дагва агсны нэрэмжит ширээний теннисний аварга шалгаруулах нээлттэй тэмцээн гэсэн хоёр төрөлд 15 аймгийн 270 гаруй тамирчид оролцлоо.

Хугацаат цэргийн албаны ээлжит цэрэг татлагыг 10 дугаар сарын 06-аас 14-ний өдрүүдэд Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад бүсчлэн зохион байгуулж, хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдах нийт иргэдэд зарлан дуудах мэдэгдэл хүргүүлсэн ба эрүүл мэндээр тэнцсэн иргэдийг Зэвсэгт хүчний анги байгууллагад хүлээлгэн өгч хяналтын тоог 90.2 хувьтай биелүүлсэн.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 9, эрэн хайх, аврах ажиллагаа 1, авто осол 2, ой, хээрийн түймэр 2 нийт 14 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 120 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-ийг тохиолдуулан 2023 оны 10 дугаар сарын 7-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрүүдэд Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр сумын 529 гэр хорооллын айл өрхийн 1645 иргэнд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, анхааруулга санамжийг өгсөн.

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг сурталчлах арга хэмжээг Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр суманд 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж нийт 1051 иргэнийг хамруулж, гамшгаас урьдчилан сэргийлэх 8 төрлийн 651 ширхэг сэрэмжлүүлэг материалыг тараан ажилласан.

Тайлант үед 3 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулж, 7 объектод галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон.

Төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 4 ажлын зургийг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Стандарт хэмжил зүйн салбарын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотод зохион байгуулсан “Иргэдэд ээлтэй Стандарт” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа. Мөн аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг төлөөлөн “Алтан тариа” ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн, “Спирт бал бурам” ХХК бяслаг, “Майнд тэч” ХХК ургамлын тос, “Михачи” ХХК зөгийн балаар тус тус үзэсгэлэн худалдаанд оролцож, бүтээгдэхүүнээ сурталчилсан.

Хүдэр, Баянгол, Мандал, Алтанбулаг сумдын 51 иргэн, аж ахуйн нэгжийн худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, 44 үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Мандал сумын 1 аж ахуй нэгжийн тослог ургамлын үр боловсруулах үйлдвэрийн 2 нэрийн 3 бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээний хугацааг сунгасан.

Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй Болдтөмөр Ерөө гол ХХК, Инфинити спэйс ХХК 2 аж ахуй нэгжийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал-MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 73 удаагийн тээвэрлэлтэд баталгаажуулалт хийж, экспортын гэрчилгээ олгосон байна.

Баян-Өлгий аймагт байрлалтай 1 аж ахуйн нэгжийн 1 нэрийн 10 төрлийн архи, виски, дарсанд 3 тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 7 нэрийн 12 стандартыг борлуулж, дотоод албан хэрэгцээнд 2 нэрийн 2 төрлийн 2 стандарт олгосон байна.

Аймгийн хэмжээнд хэмжих хэрэгслийн тооллого хийх ажлыг эхлүүлж бүх сум, байгууллагад улсын шалгагч нар тооллого хийх ажлууд хийгдэж байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

10 сард 1955 баримтаар 17,6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		87,071,068.9	75,793,384.2	590.6
1.1	Орон нутгийн төсвийн орлого	42,684,422.5	41,872,578.3	98.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	19,408,049.4	13,990,773.5	72.1
	Сумдын төсвийн орлого	23,276,373.1	27,881,804.8	119.8
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	4,173,693.4	3,862,539.6	92.5
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	12,064,231.0	4,996,443.6	41.4
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	8,255,036.8	8,255,036.8	100.0
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	2,735,242.2	-	-
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,271,823.0	1,290,720.3	101.5
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	2,534,332.0	1,279,125.0	50.5
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		87,071,068.9	64,001,788.5	73.5
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	87,071,068.9	64,001,788.5	73.5
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	38,149,109.9	32,686,466.2	85.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	13,474,815.7	8,244,742.3	61.2
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	35,447,143.3	23,070,580.0	65.1
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	6,864,586.1	2,879,962.1	42.0
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	7,791,346.4	4,386,048.2	56.3
	Халамжийн сан	122,000.0	94,339.0	77.3
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	16,153,760.0	13,068,119.6	80.9
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	950,000.0	842,796.1	88.7
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	3,565,450.8	1,799,315.0	50.5
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		13,538,274.4	4,386,048.2	-
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5,746,928.0	-	-
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-

3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	7,791,346.4	4,386,048.2	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	7,791,346.4	4,386,048.2	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
	Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага		2,534,332.0	1,279,125.0	50.5
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,534,332.0	1,279,125.0	50.5

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – IX	2023 – IX	<u>2023 - IX</u> <u>2022 - IX</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 600	3 067	191.7
	Талх /орон нутгийн, ш/	1 500	2 300	153.3
	Нарийн боов /кг/	5 000	5 934	118.7
	Будаа /кг/	3 500	3 967	113.3
	Элсэн чихэр /кг/	3 300	4 534	137.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	9 000	10 500	116.7
	Үхрийн мах /кг/	11 000	11 750	106.8
	Адууны мах /кг/	8 000	11 000	137.5
	Ямааны мах /кг/	8 000	9 000	112.5
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	16 500	16 667	101.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 200	2 334	194.5
	Сүү / савласан, л/	4 500	4 550	101.1
	Тараг /задгай, л/	1 800	2 767	153.7
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	21 867	87.5
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 600	4 550	68.9
	Өндөг /ш/	400	357	89.3
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	11 000	10 500	95.5
	Өөхөн тос /кг/	3 000	4 000	133.3
	Шар тос /кг/	25 000	29 000	116.0
	Масло /задгай, кг/	7 500	9 167	122.2

5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	2 000	1 767	88.4
	Лууван /кг/	2 500	2 200	88.0
	Манжин /кг/	2 500	3 834	153.4
	Байцаа /кг/	2 000	2 500	125.0
	Сонгино /кг/	2 500	4 334	173.4
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 600	8 667	114.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	5 500	5 817	105.8
2. ШАТАХУУН				
	Бензин А - 80	2 480	2 460	99.2
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	3 730	3 550	95.2

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Сонгуулийн ерөнхий хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Хариуцлагатай сонгогч" бэлтгэх сургалтыг орон нутаг дахь сургагч багш нар сонгуулийн насны хүүхэд, залуусын дунд зохион байгуулан ажилласан.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн сургалтыг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран Алтанбулаг, Сүхбаатар, Шаамар, Зүүнбүрэн, Жавхлант зэрэг сумдын 37 албан хаагчдад зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн албанд шинээр томилогдсон 20 агентлагийн 54 албан хаагчдад "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт зохион байгуулсан.

Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн 49 албан хаагчдад "Авлигын тухай хууль тогтоомж" "ХАСУМ, ХАСХОМ-ийг гаргах эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудлууд" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан.

Архивын тасаг:

Монгол Улсын Боловсролын их сургуульд "Архив судлал", Дотоод хэргийн их сургуульд "Эрх зүйч-архив судлал"-ын чиглэлээр архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн боловсон хүчний эрэлт хэрэгцээ, ажлын байрны судалгааг гаргаж ирүүлэх тухай албан бичгийг боловсруулж, газар, хэлтэс, албад болон сумдын Засаг даргын Тамгын газруудад хүргүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу тасгийн дарга, зааварлагч, арга зүйч нар Бугант тосгоны Захирагчийн албаны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Аймгийн Цагдаагийн газар: 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийт 620 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 49 (7.3%)-аар буурсан байна. Нийт 47151 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18684 (65.6%)-аар өссөн байна. Нийт 1647 гомдол мэдээлэл бүртгэгдэж, үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 127, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1520 бүртгэгдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2023 оны 10 дугаар сард иргэний шийдвэр гүйцэтгэх тасагт 637 гүйцэтгэх хуудас шинээр ирж, 492 гүйцэтгэлийн хуудсыг хаасан. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр

шийтгэгдсэн 16 гүйцэтгэх хуудас ирж, 45 гүйцэтгэх хуудас хааж, 207 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: 2023 оны 10 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 108, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 81, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 176, гэрэл зургийн ажлын тоо 5915, криминалистикийн шинжилгээ 41, цогцост хийсэн шинжилгээ 18-ыг тус тус хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2023 оны 10 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 142 /эрэгтэй-75, эмэгтэй-67/
- Гэрлэлтийн бүртгэл - 26
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 10
- Үрчлэлт - 3
- Эцэг, эх тогтоолт – 7 /үүнээс эрэгтэй 6, эмэгтэй 1/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 6
- Нас баралт - 53
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 341
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 128
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 46
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 167
- Гадаад паспорт олголт - 290
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 117 /үүнээс насанд хүрсэн 77, хүүхэд 40/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 121 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 507
- Анхны бүртгэл - 146
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 115
- Барьцааны гэрээ - 195
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 21
- Лавлагаа хуулбар - 16
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 281

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 576
- Анхны бүртгэл- 30
- Өмчлөх эрх шилжих гэрээ-101
- Барьцааны гэрээ- 409
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 11
- Лавлагаа хуулбар-9
- Нийт бичигдсэн гэрчилгээ-141

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 10 дугаар сарын байдлаар хүүхдийн 0-17 насны 2 багц үзлэг, оношилгоонд 24410 хүүхэд хамрагдаж, насанд хүрэгчийн 4 багцын 7400 насанд хүрсэн иргэн хамрагдлаа.

“БЗДХ-ын өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, мэдлэг хандлага өөрчлөх” сэдэвт сургалтыг 18 байгууллагын 661 иргэн, 14 сум, тосгоны 681 иргэнд хүргэсэн байна

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээг тодорхойлох урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж 314 аж ахуйн нэгж, байгууллагыг хамрууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

Ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарын мэргэшүүлэх сургалтыг 2023.10.20-21-нд Боловсролын ерөнхий газартай хамтран зохион байгуулж нийт 67 багшийг хамруулсан.

БШУ-ны Сайдын тушаалаар батлагдсан иргэдийн инновацын санаачилгыг дэмжих “MON-X” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан цахим сургалтад нийт 187 төрийн албан хаагч, боловсролын салбарын удирдах ажилтнууд хамрагдсан.

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн хүрээнд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд оролцох чиглэлээр эцэг эхчүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалт”-ыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад эцэг эх, асран хамгаалагч-10, бага ангийн багш -3 тус тус хамрагдсан.

Мэдээлэл, технологийн үндэсний парк, аймгийн БШУГ-тай хамтран аймгийн ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Хакатон” мэдээлэл технологийн тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн Үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж 60 гаруй тамирчин өрсөлдлөө.

Биеийн тамир, спортын салбарын төвийн бүсийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлт тэмцээн 2023 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Биеийн тамир, спортын Улсын хороо, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын ажилтан, албан хаагчид оролцсон.

Биеийн тамир спортын Улсын хорооны Эрдэм шинжилгээний албанаас зохион байгуулж буй Орон нутгийн өсвөрийн тамирчдаас сорил авах, мөн дасгалжуулагчдын сургалтад Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нар болон сумдын спорт цогцолборын арга зүйч, дасгалжуулагч нар хамрагдлаа. Сорилд спортын 7 төрлөөр нийт 80 гаруй өсвөрийн шигшээ багийн тамирчид хамрагдсан.

Соёл урлагийн чиглэлээр:

“Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа”-нд 10 сум 2 тосгон сонгогдож 7 ай савын хүрээнд нийт 54 өвлөн уламжлагчийг хамруулан судалгаа шинжилгээ хийж, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан тархалтыг тогтоож ажиллалаа.

Хүүхэд залуучууд гэр бүлийн чиглэлээр:

Хүүхдийн өөрийн сонирхолд тулгуурласан, хүүхдийн оролцоог дэмжсэн, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, авьяас чадвараа нээн илрүүлэх зорилготойгоор

Мандал сумын Хүүхдийн ордноор 5 төрлийн дугуйланд 61 хүүхэд, Орхонтуул сумын Хүүхэд хөгжлийн төвөөр 6 төрлийн дугуйланд 47, байгууллагын дэргэдэх 2 төрлийн дугуйланд 15, нийт 123 хүүхэд хамрагдсан.

Сүхбаатар сумын Хүүхдийн зөвлөлийн чуулганыг “Тэгш оролцоо – Хязгааргүй боломж” уриан дор зохион байгуулж, нийт 131 хүүхэд, 19 насанд хүрэгч хамрагдсан.

Бэлгийн хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Бэлгийн боловсрол” олгох сургалтыг 5 Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 380 сурагчдад танхимаар зохион байгуулж, 17 сумын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд цахим хичээлийг түгээсэн.

Бэлгийн хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Аюулын дохио аюулгүйн дүрэм” сургалтыг 8 сургуулийн өмнөх боловсролын нийт 241 хүүхдэд зохион байгууллаа.

“Хайраар хамгаалъя” аяны хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Жинхэнэ эр хүн, аав хүн”, “Яг өнөөдрөөс гэр бүлдээ” “Хүүхдийн хөгжил, онцлог”, “Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал” сэдэвт сургалтыг Гэр бүл, судлаач, лектор Ж.Баясгалан багшийг урьж Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Алтанбулаг сумын ЗДТГ, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1, 4, 6 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэгийн багш, албан хаагч, эцэг эхчүүд нийт 600 гаруй иргэнийг хамруулан зохион байгууллаа.

Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалтыг Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дунд ангийн сурагчдад зохион байгуулж, 98 сурагч хамрагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал чиглэлээр:

Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг 13 ахмад настанд 62000.0 мянган төгрөг, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 86000.0 мянган төгрөг, 19 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 167000.0 мянган төгрөг, нийт 44 иргэнд 315000.0 мянган төгрөгийг ХЭДСангаас эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олголоо.

Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн иргэний суралцах мэргэжлийн чиглэл, боломжийн талаарх хүсэлтэд үндэслэн мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад ажилгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй Мандал сумын 14 иргэнд гоо засалчийн мэргэжил олгох сургалтад хамрууллаа.

"Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангахад ажил олгогчдын оролцоо" сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 60 орчим аж ахуйн нэгж байгууллагын 70 гаруй ажил олгогч, ажилтан албан хаагчид хамрагдлаа.

- Төрийн банктэй хамтран “Ажлын байрны өдөрлөг, үзэсгэлэн худалдаа”-г 10 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулж 71 ажил олгогчоос ирүүлсэн 300 гаруй ажлын байрны захиалгыг иргэдэд танилцуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлага материалыг тарааж ажиллалаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

2023 оны 10 дугаар сарын байдлаар 166.5 мянган тн үр тариа, тэжээлийн ургамал 12.9 мянган тн, тосны ургамал 15.7 мянган тн, төмс 29.9 мянган тн, хүнсний ногоо 55.9 мянган тн тус тус хураан авсан.

Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд "Хоршоод хамтдаа -20 жил хөгжлийн шинэ эхлэл" зөвлөгөөнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын Хөдөө ахуйн хоршоологчдын Үндэсний холбоо, аймгийн засаг даргын Тамгын газар, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага, хоршоодын төлөөлөл нийт 180 хүн оролцож, "Ургацын далай" тогоочдын ур чадварын уралдаан, "Хоршоологчдын Брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа"-г зохион байгуулсан.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/473 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд үржилд ашиглаж буй 4196 хуц, 2758 ухна нийт 6954 толгой бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийж бүртгэлжүүлэв.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Мялзан өвчний дархлаажуулалтыг хийж, вакцинд хамрагдсан сүргийн дунд үүссэн дархлааны түвшин, вакцинд хамрагдалтын хувийг тогтоох зорилгоор тандалт шинжилгээний сорьц дээж цуглуулах ажилд 6 сумын 15 багийн 36 малчин, мал бүхий өрхийн 216 толгой бог малыг хамруулж удирдамж, арга зүйг баримтлан сорьц дээжийг цуглуулан Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторид хүргүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Орхон суманд хийгдэж байгаа хөв, цөөрмийн ажлын зураг төсөвт өөрчлөлт оруулах асуудлыг гүйцэтгэгч байгууллагатай зөвшилцөн түшиц ханыг өөрчлөх асуудлаар албан бичиг хүргүүлэн ажиллаж, захиалагчийн хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.

Хууль бус самрын зөрчил идэвхжих хандлагатай байгаа учраас "Самар" нэгдсэн аяныг өрнүүлэн хамгийн их зөрчил гарч буй Баруунбүрэн сумын нутагт 20 гаруй хүнийг албадан буулгаж 13 зөрчилд 3,9 сая төгрөгийн торгууль ногдуулж 1,7 тн самар хураагаад байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын санал, суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг шинэчлэн тогтоох, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын саналыг нэгтгэн хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд: Энэ онд 21.5 тэрбум төгрөгийн 95 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 53, харьцуулалтын аргаар 33, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт 4, шууд худалдан авалт 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 69 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулах эрх олгосон нь 72.6 хувийн гүйцэтгэлтэй, төсөл арга хэмжээний гэрээг www.tender.gov.mn цахим системд оруулж олон нийтэд тухай бүр нийтэд мэдээлсэн.

Улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 10 ажлын гүйцэтгэлийн материалыг хянаж, 300 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, Баруунбүрэн суманд орон нутгийн хөгжлийн сангийн 171 сая төгрөгийн

санхүүжилтээр хэрэгжсэн бордооны цех байгуулах тоног төхөөрөмжийг хүлээн авсан.

Тендерийн үнэлгээний хороонд ажиллах гишүүд 20 удаагийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 82 төрийн албан хаагчийг худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамруулан ажилласан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд: 2023 оны төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу 5 хяналтын чиглэлээр 91 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 48 аж ахуй нэгжид 384 заалттай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, албан шаардлагын биелэлт 80 хувьтай байна.

Мөн хяналт шалгалтын хүрээнд 3 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоосон 3 акт үйлдэж, улсын байцаагчийн дүгнэлт 3, зөвлөмж 6 гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

Хяналт шалгалтын явцад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нь тогтоогдсон 4 иргэн, 12 аж ахуй нэгжид зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 6 хэрэгт зөрчлийн хэрэг нээсэн 10 хэргийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж нийт 4 иргэн 8 аж ахуй нэгжид нийт 12,4 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, торгууль шийтгэврийн барагдуулалт 80 хувьтай байна.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл нөөцөө хангахаар цаг хүндэрсэн үед хэрэглэх 40 тн байгалийн хадлан, өвсний нөөц бүрдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Байгалийн хадлан өвсний нөөц бэлтгэх ажлын хүрээнд Алтанбулаг сумаас алслагдсан Цанатах, Хазаа, Шандын чиглэлд хадлан бэлтгэж буй иргэн аж ахуй нэгжүүдтэй өвсний нөөц бэлтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. "Ачмаг наран" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд сумын нөөцөд 1000 боодол буюу 20 тн байгалийн хадлан бэлтгэж хүлээлгэн өгч өвсний нөөц бүрдүүлэлтийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд Ойн санг гэрээгээр эзэмшигч болон мод үржүүлгийн аж ахуйн нэгжүүд, бусад байгууллага иргэд 2023 оны хавар, намрын мод тарих ажлаар 224018 ширхэг мод бутыг тарилаа.

Бүх нийтийн мод тарилтыг 2023 оны 10 дугаар сарын 13-аас 14-ний өдрүүдэд зохион байгуулж хайлаас, үхрийн нүд, монос, гүйлс агч 5 төрлийн 277 ширхэг модыг тарьсан.

40-65 насны 1430 иргэдийг халдварт бус өвчнийг эрт илрүүлгийн үзлэгт хамруулахаас цусны даралт ихдэх өвчний эрт илрүүлэгт 886, чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 881, элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 406, умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 66 эмэгтэйг хамруулж 40%-тай ажиллаж байна.

Баруунбүрэн сум:

Газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч 24 аж ахуй нэгж, 15 иргэн 11200 га талбайд уриншийн боловсруулалт хийж энэ онд 11148 га талбайд улаан буудай, 80 га талбайд овъёос, 50 га талбайд вандуй, 609 га талбайд тэжээлийн ургамал,

3383 га талбайд тосны ургамал, 38 иргэн 30 га талбайд төмс, 37 га талбайд хүнсний ногоо тариалсан.

“Газар агро” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд үхрийн үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 4 бухан бяруу хүлээлгэн өгснийг 4 өрхөд хуваарилан өглөө.

Аймгийн мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагч, лабораторийн шинжээч эмч нарын хамт сумын мал эмнэлгийн тасаг бог малын мялзан өвчний хаврын вакцинжуулалтын ажлын үр дүнг үнэлэх зорилгоор тус сумаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 6 өрхийн 12 толгой ямаа, 12 толгой хурга, 12 толгой ишиг нийт 36 толгой малаас цусны дээж авч ажиллалаа.

9-10 дугаар ангийн сурагчдад “Цагийн төлөвлөлт” сэдэвт сургалтыг Ерөнхий боловсролын сургуулиас зохион байгуулахад нийт 42 суралцагч хамрагдсан.

Сургуулийн 7-15 насны 95 суралцагчдыг Сахуу татрангийн вакцинд хамрууллаа. 10 дугаар сард Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах 10 хоногийн аяны хүрээнд 2-5 насны хүүхдүүд, ахмадууд, архаг хууч өвчтэй хүмүүс, эмч эмнэлгийн ажилчид нийт 240 хүн хамрагдлаа.

Баруунбүрэн сумаас 7 соёлын өвийг Соёлын өвийн газрын мэргэжилтнүүд аймгийн соёл урлагийн газрын мэргэжилтэнтэй хамтран бүртгэл мэдээллийг хийж баримтжууллаа.

Тоон гарын үсгийг 103 иргэнд олгож, өссөн дүнгээр 950 иргэн тоон гарын үсгээ авлаа. Иргэний улсын бүртгэлийн лавлагаа 28 иргэнд олгож, нийт 163 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Баянгол сум:

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор байгалийн ургамал ашиглаж буй малчин болон мал бүхий иргэдэд хяналт тавьж байгалийн ургамал болон хадлан хадах газрыг Хараа, Баян, Гонир багуудад тогтмол багийн засаг дарга нартай хамтран гүйцэтгэж байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Байгалийн гэнэтийн гамшиг осолтой тэмцэх урьдчилан сэргийлэх, ой хээрийн түймрээс сэргийлэх санамж бичиг зурагт хуудсыг Баянгол сумын байгаль орчин цахим хаягт байршуулан сурталчилж байна.

10 дугаар сарын байдлаар 1709,7 га талбайгаас 8493,4 тонн үр тариа, үүнээс: 7146,6 тонн улаан буудай, 1989 тонн төмс, 1635,9 тонн хүнсний ногоо, 803,8 тонн тэжээлийн ургамал, 543 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна. Үүнээс төмс, хүнсний ногооны хураалт 100 хувьтай байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг “5Ш” ажиллагааны нэг болох “Шүгэл” ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” авлигын эсрэг нөлөөллийн аяныг “Сэлэнгэ аймаг Баянгол сум” цахим хуудсаар дамжуулан сурталчлан ажиллаж байна.

Ерөө сум:

Жил бүр уламжлан болгон зохион байгуулагддаг “Ерөө бүсийн төрийн албан хаагчдын спортын нөхөрсөг тэмцээн” 2023 оны 10 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд Хүдэр суманд зохион байгуулагдахад 80 гаруй төрийн албан хаагчид оролцон хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж “Ерөө сум”-ын төрийн албан хаагчид багийн дүнгээр цомын эзэд болсон.

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангахаар өнөөдрийн байдлаар өрхийн хэрэгцээнд 12450 тн хадлан бэлтгээд байна.

Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор ажлын хэсэг байгуулагдан сумын хэмжээний бог малын хээлтүүлэгч үзлэг ангилалтыг хийж дуусган айл өрхүүдэд технологит хугацаанд нь хүлээлгэн өглөө.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд төр төсвийн 5 байгууллагын 120 ажилтан, албан хаагчид, “Төгөлдөр-Ерөө” ОНӨААТҮГ-н 85 ажилчид, иргэд оролцлоо.

“Болд Төмөр Ерөө гол ХХК”-н туслан гүйцэтгэгч “Инфинити спейс” ХХК нь хайлаас 2800, агч 2000, монос 100, өрөл 100 ширхэг тарьц суулгацыг нийлүүлсэн байна.

Улирлын томуугийн эсрэг вакциныг жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрлөөр 2-5 насны хүүхэд зэрэг нийт 269 хүн буюу 92.8 хувийг хамруулсан. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн 766 сурагчдын дунд эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулахад хүүхдийн шүдний өвчлөл 378 буюу 49.3 хувийг эзэлж байна.

Жавхлант сүм:

Ахмад настанд үзүүлэх "ӨДРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" арга хэмжээг 2023.09.27-нд сумын Улаан загалмайн Анхан шатны хороо, аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар, сумын соёлын төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд:

Цэцэрлэг танин мэдэхүйн "АХА", Ерөнхий боловсролын сургууль хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, АХА тэмцээнд:

- Ахмад настан Х.Цэрэндаш,

- Хөгжөөнт тэмцээний Тэргүүн байрт Ж.Тунгалаг, Дэд байрт С.Батдорж шалгарлаа. Эрүүл мэндийн төвөөс тус үйл ажиллагааг дэмжин витаминжуулалт, анхан шатны тусламж болон зөвлөгөө мэдээллээр үйлчиллээ.

2023 оны 2 дугаар ээлжийн цэргийн албаны татлагад бэлтгэн Жавхлант болон Хушаат сумын цэргийн насны нийт 31 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, Жавхлант сумаас 17 иргэн цэргийн албаны татлагад хамрагдсанаас 3 иргэн тэнцсэн.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2012 оноос эхлэн жил бүрийн 1□0 дугаар сарын 1□1-ний өдрийг Олон Улсын Охидын өдөр болгон тунхагласан. Жавхлант сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл, ЭМТ, ЕБС-тай хамтран "ОХИДОО СОНСЪЁ-ХАЙРЛАЯ" хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Соёлын биет бус өвийн улсын үзлэг тооллогын төвийн бүсийн баг бүрэлдэхүүн Жавхлант суманд 2023.10.16-аас 17-ны өдрүүдэд ажиллан соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 7 өвлөн уламжлагчийн 10 төрлийн өвийг судлан баримтжууллаа.

Ерөө бүсийн Төрийн албан хаагчдын дундах 4 төрөлт спортын нөхөрсөг тэмцээн Хүдэр суманд зохион байгуулагдсан бөгөөд тэмцээнд 4 багийн 80 гаруй тамирчид оролцлоо.

"Намрын мод тарилт", "Сумын тохижилтыг сайжруулах" ажлын хүрээнд Бумбат 1 дүгээр багийн иргэн Н.Ганзориг нь сумын ОНХС-ийн 15.3 сая төгрөгийн санхүүжилтээр төвлөрсөн хогийн цэгийн баруун талаар нь 450м×7 м-ийн торон хашаа барьж өөрийн хашаанд үржүүлсэн 3 настай 150ш агч, 150ш улиас мод нийт 300ш модыг тарьж суулган, усалгааг хийгээд байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажил хийгдэж байна.

Зүүнбүрэн сум:

Мэдээллийн ил тод байдлыг ханган иргэдийг мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хөдөө аж ахуйн салбар, статистик, ойн анги, эд хөрөнгийн улсын бүртгэл, иргэний бүртгэл, өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах, цаг үеийн мэдээлэлтэй холбоотой 10 видео бичлэг, зарын чанартай 18, үйл явдлын 15, цаг үеийн 10, бүтээн байгуулалтын 2 мэдээ, мэдээлэл бэлтгэн боловсруулж байгууллагын цахим хаягт байршуулан олон нийтэд хүргэн ажиллалаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Зүүнбүрэн аян”-ны хүрээнд сумын Засаг даргын Тамгын газрын 22, Ерөнхий боловсролын сургуулийн 10 багш, 12 дугаар ангийн 20 суралцагч, төр, төсвийн байгууллагын 45 албан хаагч хамтран 640 монос, гүйлс, буйлс, агч, үхрийн нүд зэрэг мод шинээр тарьж, 250 модонд арчилгаа хийлээ.

2023 оны 2-р ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад хамрагдах залуусын судалгааг гаргаж, “Цэргийн жинхэнэ албанд зарлан дуудах мэдэгдэл”-ийг биечлэн хүргэх ажлыг зохион байгуулж, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдуулан ажиллалаа.

Олон Улсын “Ахмадын баяр”-ын хүрээнд сумын Ахмадын хороотой хамтран 130 гаруй ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлж “Жуух бичиг”-ээр 5 ахмадыг шагнаж, хүндэтгэлийн тоглолт үзүүлж, хөгжөөнт тэмцээн, азын сугалаа, эрүүл мэндийн үзлэг зохион байгууллаа.

Орчин цагийн боловсролын байгууллага үүсэж хөгжсөний 102, Монголын багш нарын 57 дахь өдрийг сумын боловсролын байгууллагууд тэмдэглэн өнгөрүүлээ. Тус арга хэмжээнд үе үеийн ахмад багш ажилчид оролцож, Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын газар, аймаг, сумын шагналуудаар шагнагдлаа.

2023-2024 онд сумын хэмжээнд 569 малчин, мал бүхий иргэдийн нийт 91422 толгой мал өвөлжих бөгөөд 284 малчин өрхийн өвөлжөө засвар хийгдэж өвөлжихөд бэлэн болсон байна.

Сумын хэмжээнд 233 иргэн, 1 аж ахуй нэгжтэй 3519 га талбайд хадлангийн газар ашиглуулах гэрээ байгуулан хадлан бэлтгэл 100 хувь буюу 8000 тн өвс, ногоон тэжээл 57,3 тн тус тус бэлтгэн, сумын аюулгүй нөөцөд 1650 боодол буюу 33,000 кг өвсийг төвлөрүүлээд байна.

Өвөлжилтийн үед хүндэрч болзошгүй Мангирт 3 дугаар багийн “Орос даваа”, Бэлчир 2 дугаар багийн “Бонгийн тохой” гэх газруудын автозам даваануудыг дотоод нөөцдөө тулгуурлан сэргээн засварлалаа.

Сумын дүнгээр улаан буудай 15149 тн ургац, тосны ургамал 2166,4 тн, тэжээлийн арвай 1166 тн, эрдэнэ шиш 1600 тн, олон наст тэжээлийн ургамал 805,4 тн, овьёос 501,8 тн-ыг хураан авч, улаан буудайн борлуулалт 40 хувьтай байна.

“Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтад 20100 үхэр, 400 гахай нийт 20500 тун вакцин ирснээс 10 дугаар сарын байдлаар 3500 үхэр, 400 гахай нийт 3900 тун вакцин хийгдэж 63 хувьтай явагдаж байна.

Мандал сум:

2023 оны 10 дугаар сарын 06,07,08-ний өдрүүдэд хугацаат цэргийн албаны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгууллаа.

Цэргийн насны залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 5 сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад цэргийн зарлан дуудах хуудсыг хүндэтгэлтэй тарааж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа. Хоёрдугаар ээлжийн цэрэг татлагад 18-25 насны 300 гаруй залуусыг хамрууллаа.

Мандал сумын Засаг даргын Тамгын газар, сумын Ахмадын хороотой хамтран ахмадын баярын өдрийг угтан баярын хурал хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 09 сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

Монголын багш нарын баярын 57 дахь өдөр, Дэлхийн багш нарын баярын 29 дахь өдрийг тохиолдуулан баярын хурал, хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 10 сарын 06-ний өдөр зохион байгуулж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагын багш, ажилчдыг тэгш хамруулан өнгөрүүллээ.

“Олон нийтэд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг систем, үйлчилгээг хөгжүүлэх” туршилтын төсөл 2022 оноос хэрэгжиж эхэлсэн ба төслийн хэрэгжилт явцын талаар удирдах зөвлөлийн гишүүд төслийн багийнхантай 2023 оны 10 сарын 16-ний өдөр уулзалт хийж цаашид хэрэгжүүлж болох ажил арга хэмжээний талаар санал солилцлоо. Энэхүү төслийг хэрэгжүүлэх ажлын явц нь Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг түшиглэн “Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийг байгуулан сэргээн засах, уламжлалтын тасагтай хамтран ахмад настуудад чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулах зэрэг судалгааны шатанд явж байна.

Кристина Нобелийн хүүхдийн сан нь 2015 оноос Мандал сумын зорилтот бүлгийн 40 хүүхдийг хөтөлбөртөө хамруулан бие даан ажиллаж ирсэн ба цаашид Мандал сумын Хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллах саналыг оруулж Зүүнхараа хүүхдийн ордноос хариуцаж ажиллахаар санамж бичигт гарын үсэг зурлаа.

Ахмад настны тухай хуулийн дагуу протез, ортопедийн хэрэгсэл шаардлагатай 20 ахмад, магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд амарсан 35 ахмадад нийт 7,6 сая төгрөгийн хөнгөлөлтийг олголоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу байнгын асаргаа шаардлагатай 81 хүүхэд, 53 иргэн, хүндэт донор ахмад настан 4 иргэн, харж хандах үр хүүхэдгүй ганц бие 3 ахмад нийт 141 иргэнд түлшний хөнгөлөлт, протез ортопедийн хэрэгсэл шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэнд хөнгөлөлт үзүүлэв.

2023 оны ургац хураалтын явц үр тариа 5000 га талбайгаас 6000тн, ногоон тэжээл 140 га талбайгаас 740тн, төмс 500 га талбайгаас 550тн, хүнсний ногоо 500 га талбайгаас 560тн ургац тус тус хураан аваад байна.

2023 оны шүлхийн дархлаажуулалтын ажлын хүрээнд сумын 7 мал эмнэлгээр дамжуулан 395 өрхийн 12813 үхэр, 890 гахай нийт 13709 толгой малыг тарилгад хамрууллаа.

Орхон сүм:

Цэргийн жинхэнэ албаны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага Сэлэнгэ аймгийн Сайхан суманд 2023 оны 10 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Сумын хэмжээнд 80 иргэнд зарлан дуудах мэдэгдэл өгснөөс 32 иргэн үзлэгт хамрагдаж, 6 иргэн цэргийн жинхэнэ албанд татагдлаа.

Сумын Улаан загалмайн анхан шатны хороо, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран “Ахмадын өдрийн үйлчилгээ” арга хэмжээг зохион байгуулж 40 ахмад настныг хамрууллаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цемент Шохой” ТӨХК нь нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд монос, хөх далан хальс, үхрийн нүд зэрэг 3000 ширхэг модны суулгацыг нийлүүлж, нийт 17 аж ахуйн нэгж, байгууллага, 215 айл өрхөд тараалаа.

Сумын хэмжээнд улаан буудай 8239 тн, овьёос 72 тн, арвай 12 тн, тэжээлийн ургамал 997 тн, тосны ургамал 1601,5 тн, төмс 9000 тн, хүнсний ногоо 15588 тн-г тус тус хураан авсан байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 130 өрхийн 2560 тугал, 106 өрхийн 22400 хурга, ишгийг хамруулж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын явц 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орхонтуул сүм:

10 сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр 52 иргэнд 15,755,510 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 47 иргэнд 13,150,806 мянган төгрөг, цалинтай ээж 0-3 насны хүүхдээ асарч байгаа 52 эхэд 2,492,096 мянган төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 12 эхэд 443,870 мянган төгрөг олгов.

Ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахад 210 ахмад оролцлоо.

Олон улсын багш нарын баярыг угтан тэдний хийж бүтээж буй ажлыг хүүхэд, залуучууд, иргэдэд сурталчлан таниулах, үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор 2 дох жилдээ уламжлал болгон багш нарын баярын арга хэмжээг 10 дугаар сарын 05-ны өдөр Соёлын төвд зохион байгууллаа.

Гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын дараах дархлааны хувийг тогтоох тандалтын ажлыг түүврийн аргаар сонгогдсон 6 өрхийн тус бүр 3 хонь, 3 ямаа нийт 36 бог малаас дээж авч аймгийн мал эмнэлгийн лабораторид хүргүүлж ажилласан.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд Сумын засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хяналт шалгалт хийж, хуулийн чиглэлээр заавар зөвлөгөө өгч ажилласан.

Сайхан сүм:

Олон Улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Сайхан сумын Ахмадын хороотой хамтран сумын нийт ахмадуудад “Настны Жаргал” баярын арга хэмжээг зохион байгуулж, АХА тэмцээн, бүжгийн тэмцээн, урлагийн үзүүлбэр, нийтийн бүжиг, босоо хүлээн авалт зохион байгуулан ажилласан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон, Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн хамтарч 2023 оны 10 дугаар сарын 14-ний өдөр эрүүл орчинд ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгоор 150 агч, 50 монос мод тарьж, цэнэг усалгаа хийж ажилласан.

Хугацаат цэргийн албаны ээлжит татлагыг 1997.01.01-ээс 2005.10.18-ны өдөр төрсөн 2-р зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулан 2023 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Дэлхийн багш нарын 29, Монголын багш нарын 57 дахь өдрөөр Ерөнхий боловсролын 3 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 4 цэцэрлэгийн нийт 252 багш, ажилтан албан хаагч нар баярын хурал зохион байгуулж, багш, сурагчдын урлагийн үзүүлбэр, Засгийн газар, аймаг болон сумын шагналыг гардуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Олон Улсын Охидын эрхийг хамгаалах өдрөөр Эмэгтэйчүүдийн холбоо, сургуулийн Нийгмийн ажилтан нар хамтран Сайхан ерөнхий боловсролын 1, 2, 3-р сургуулийн ахлах ангийн охидод “PINK DAY” арга хэмжээг зохион байгуулж 1-12 дугаар ангийн 180 эмэгтэй сурагч хамрагдлаа. Хэлэлцүүлгээр охид өөрт болон үеийн охидод тулгамддаг асуудлаа 5 багт хуваагдан илтгэл танилцуулга бэлтгэж, хэлэлцүүлгээс гарсан саналыг Монголын эмэгтэйчүүдийн холбоонд хүргүүлэн ажиллалаа.

Сант сүм:

2023 оны хаврын тариалалтын мэдээг Plant.mofa.gov.mn цахим системд бүтгүүлэх ажлыг зохион байгуулж үр тариа, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 аж ахуйн нэгж, 43 иргэний мэдээг тус программд шивж орууллаа.

10 дугаар сарын 6-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан “Мал аж ахуйн сэргэлт” залуу малчдын үндэсний чуулганд сумаас залуу малчин Х.Энх-Амгалан, Г.Мөнхбат нарыг сонгон оролцууллаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 10 дугаар сарын 24-ний өдөр сумын төр төсвийн 5 байгууллага 10 төрлийн 102 ширхэг мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.

Хоёрдугаар ээлжийн цэрэг татлага хуваарийн дагуу 2023.10.10-ны өдөр Сайхан суманд зохион байгуулагдаж сумаас 36 хүн хамрагдаж 6 иргэн цэргийн албанд тэнцсэн.

Дэлхийн багш нарын 29 дэх, Монголын багш нарын 57 дахь өдрийг тэмдэглэх Сант сумын боловсролын салбарын баярын хурал 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдаж сумын удирдлагуудын зүгээс ажил мэргэжлээрээ тэргүүлсэн багш ажилтнуудыг шагнаж урамшуулав.

Олон улсын "Охидын эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан сумын Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Эмэгтэйчүүдийн холбооны Сант салбар зөвлөл хамтран “Охидоо сонсьё-Pink day” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Ерөнхий боловсролын сургуулиас “Аюулаас аврах 12 алхам”, “Охидоо хайрлая, хүндэлье” Эрүүл мэндийн төвөөс “Өглөөний цайны ач холбогдол”, “Эрүүл амьдрах зөв дадал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, халамж үйлчилгээний чиглэлээр нийтийг хамарсан ажлын хүрээнд сумын “Цэцэрлэгт хүрээлэн”-ийн тохижилтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд зохион байгуулан ажиллалаа.

Сүхбаатар сүм:

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Шүүхийн тухай ойлголт, иргэний шүүхэд мэдүүлэх эрх”, Төрийн цахим үйлчилгээний “Хурдан” цэг, үйл ажиллагаа, үйлчилгээний талаар, “Төрийн нийтлэг системүүд”, “Цахим ур чадвар”, “Мэдээллийн аюулгүй байдал”, “Тоон гарын үсэг түүний хэрэглээ сэдэв”-үүдээр сургалт зохион байгуулж, 8-н багийн 80 гаруй иргэн хамрагдсан.

2022 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад Сүхбаатар сумаас татагдан Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудад алба хаасан цэргүүдээ угтан авах ажлыг 2023 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулж, алба хаагчдад хүндэтгэл үзүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойргийг баг тус бүрээр шинэчлэн тогтоож 5-р сард аймгийн Боловсрол шинжлэх ухааны газарт хүргүүлж, сургуулийн өмнөх 9 цэцэрлэгт 1836 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо шинжилгээнд хамрагдалтын хувийг 10 сарын байдлаар гаргасан. Үүнд:

1. Цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэгд хамрагдсан хүний тоо – 3380
2. Чихрийн шижингийн эрт илрүүлэгд хамрагдсан хүний тоо – 3401
3. Хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгд хамрагдсан хүний тоо – 340
4. Элэгний өмөнгийн эрт илрүүлэгд хамрагдсан хүний тоо – 451
5. Дох тэмбүүгийн шинжилгээ - 68

Сүхбаатар сумын хүүхдийн чуулганыг 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж 150 сурагч оролцлоо.

“Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд хамтарсан багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалтад 1-8 дугаар багийн иргэд оролцсон.

Сумын хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын байдлаар ургац хураалт төмс 105.8 цн, хүнсний ногоо 110,2 цн тус тус хураан авч ургац хураалтын ажил 100 хувьтай явагдаж дууссан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сүхбаатар сумын Засаг даргын 2023 оны “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах тухай” А/330 дугаар захирамжийн дагуу 10 дугаар сарын 20-ны өдөр Бор гүвээ 5-р багийн байрлах аймгийн Онцгой байдлын газрын “Онцгой төгөл”, “Агро парк”-ын хашаанд 16 төрлийн 800 ширхэг навчит болон шилмүүст мод тарьсан.

Сүхбаатар суманд аймгийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар дараах ажлууд хийгдлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Номин" буудлын өмнөх авто замын уулзварын хэсгээс тариан түрүүтэй авто замын уулзвар хүртэлх зам талбайд 4 эгнээ хатуу хучилттай авто зам байгуулах ажил дуусаж замын хөдөлгөөнийг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хэвийн горимд шилжүүлсэн.
- Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,9 сая төгрөгийн зардал гарган Ганзам 7-р багийн 60-н айлын дунд замд 311м хатуу хучилт, баруун талын туслах замд 92,55м хатуу хучилт хийх ажлыг "Цагаан эрэг тохижилт үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтран гүйцэтгэсэн.
- Орон нутгийн төсвийн 80,000,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ган зам 7 дугаар багийн нутагт сагсан бөмбөгийн болон бялдаржуулах талбай байгуулсан.

- Орон нутгийн төсвийн 50,396,190 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаан эрэг 2 дугаар баг “Эмнэх баг” өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын цэвэр усны шугам, хоолойг шинэчлэн засварласан.
- Орон нутгийн төсвийн 60,000,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сум доторх автозамын зорчих хэсгийн эвдэрч, хагарсан 800 м2 талбайд асфальт, битүмээр нөхөөс хийх ажлыг “Дэвжих таван хан” ХХК хийж гүйцэтгэсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн 7,770,500 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын өвсний нөөц бүрдүүлсэн.

Түшиг сүм:

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Улаан загалмай хорооноос санаачлан ахмад настанд үзүүлэх "ӨДРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээг газар дээр нь хүргэж, ахмадуудын дунд хөгжөөнт АХА тэмцээн, гар зургийн уралдаан зохиосон.

Хуурайшилтын үед ойд мод бэлтгэх тээвэрлэх үйл ажиллагааг зогсоож галын аюулгүй байдлыг хангуулах талаар иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг өгч ажиллаж байна.

Намрын ойжуулалтаар “Мойлт нуга” ХХК 115 ширхэг, “ММЭ Түшиг” ХХК 115 ширхэг “Шинэбадрах” ХХК 115 ширхгийг тус тус тарьж 20*100 метр хашаа барьж хамгаалан 75 иргэнийг хамруулж 450 ширхэг мод тарьж ургуулсан байна.

Бүгд найрамдах Буриад улсын Улан-үдэ хотын Иволгинский районы “Золотинко” цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан хамтран ажиллах гэрээ байгуулан цаашид хийх ажлыг төлөвлөн зохион байгууллаа.

Багш нарын баярын өдрийг тохиолдуулан “Сайн багш” эцэг эхийн нэг өдрийг амжилттай зохион байгуулан хамтран ажиллаа. “Алтан намар” экскурс аяллыг зохион байгуулж бэлтгэл бүлгийн сурагчид “Бооцын тариа” ХХК-ны тариалангийн талбайд зочилж мэдлэг хуримтлууллаа.

Хүүхэд хүчирхийлэлд өртөх болон эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж “ГАРААС ГАРТ” журмыг хэрэгжүүлэн эцэг эх, асран хамгаалагчтай хамтран эргүүл жижүүрийг ажиллуулж байна.

10,11,12-р ангийн нийт 15 сурагчдыг хамруулан “Охидын хэлэлцүүлгийг” сургуулийн нийгмийн ажилтан, багш нартай хамтран зохион байгууллаа .

1-12-р ангийн 352 сурагчдыг сумын ЭМТ-тэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 1-5-р ангийн нийт 173 сурагчдын эрүүл мэндийн картыг шинэчилсэн.7,15 настай хүүхдийн судалгаа гарган сахуу татрангийн вакцинд хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Хушаат сүм:

10 сарын байдлаар ургац хураалт 9037 га талбайгаас 14708 тн , овъёос 162 га талбайгаас 99 тн, тосны ургамал 947 га талбайгаас 360 тн, төмс 197,5 га талбайгаас 3680 тн, хүнсний ногоо 236,5 га талбайгаас 5521,6 тн ургац хураасан байна.

Цэцэрлэгийн нийт 62 хүүхдийг томуугийн эсрэг вакцинд хамруулсан.

“Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан сургалт явуулж, охидтой ярилцан, санал хүсэлтийг нь сонсож “Охид”-ын клубтэй боллоо.

Ахмад залуу үеийн багш нарын залгамж хамтын үйл ажиллагааг бэхжүүлэх, ахмад багш нарын арга ур чадвараас суралцах зорилготой жил болгон уламжлал болгон зохион явуулдаг "Залуу багшийн ур чадвар"-ын уралдаан амжилттай зохион байгуулагдлаа.

2023 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулан цэргийн насны 13 иргэнийг үзлэгт хамруулан ажилласан.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтыг Монголын Анчдын нийгэмлэг төрийн бус байгууллагаас 2 мэргэжилтэн ирж 2 хоногийн хугацаанд байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар хамтран зохион байгууллаа.

Хүдэр сум:

Тухайн сарын байдлаар сумын төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2,420,654,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 ажил хийгдэхээс 100 хувийн гүйцэтгэлтэй 7 ажил, 50-90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж буй 3 ажил, тендер зарлагдсан 1 ажил байна.

Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн лавлагаа 45 иргэн, тоон гарын үсгийг 26 иргэнд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрчилгээ 6 иргэнд, үл хөдлөхийн гэрчилгээ 1 иргэн нийт 122 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Хүүхэд, гэр бүл хамгааллын хамтарсан багаас ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдын дунд охидын эрхийг сурталчлах хүйсээр ялгаварлах, хүйсийн тэгш бус байдлыг шийдвэрлэх, хүчирхийллээс ангид байх, үе тэнгийнхнээр дамжуулан тэдэнд нөлөөлөх ажлын хүрээнд “Би ингэж өөрчилмөөр байна” мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулж тус тэмцээнд 9 багийн 27 хүүхэд оролцлоо.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран ЕБС-ийн 8-12 дугаар ангийн нийт 50 охидын дунд “Pink colour day” өдрийг бидний амьдарч буй нийгэм ямар байхыг хүсэж байгаа талаар охидын дуу, хоолойг сонсох ажлыг зохион байгуулсан.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор “Хүдэр сум нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг сумын Байгаль орчны алба, Хан хэнтийн улсын тусгай хамгаалалтай газар, Экологийн цагдаа, Эрэн хайх аврах салбар, Хилийн 0236-р салбартай хамтран зохион байгууллаа.

Цагааннуур сум:

10 дугаар сарын байдлаар 13000 тн өвс, 22 тн хужир шүү, 200 тн ногоон тэжээл бэлтгэсэн байна.

УИХ-н Д.Өнөрболорын санаачилгаар баригдсан нэгдсэн хүлэмжийг авч ашиглах хүсэлт өгсөн иргэдийн материалыг хянан үзэж 3 ААН, 2 Хоршоо, 25 бүлэг бүхий иргэдэд хуваарилах ажлыг зохион байгуулан ажилласан.

2023 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар улаан буудай 18673 тн, тосны ургамал 1851 тн, тэжээлийн ургамал 8491 тн, овьёос 203 тн, арвай 140 тн ургац тус тус хураан авсан байна.

“Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд нийтийн эдэлбэр газарт шинээр 1 га ногоон байгууламжийн талбай бий болгож 1270 мод тарьсан.

ЕБС-ийн 7-9 дүгээр ангийн хөвгүүдэд "Электрон тамхины хор нөлөө", "Үе тэнгийнхний дээрэлхэлт"-ээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийж уг үйл ажиллагаанд 140 хүүхдийг хамрууллаа.

Сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл, ЕБС-ийн сэтгэлзүйчтэй хамтран Олон Улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "АМИНЧХАН ЯРИА" аялангаа ярилцъя хэлэлцүүлэгт арга хэмжээг ЕБС-ийн 6-7 дугаар ангийн 96 охидын дунд 5 бүлэг болгож зохион байгууллаа.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. 10 дугаар сарын 25-ны байдлаар 46 өрхийн 3040 толгой үхэр таригдсан ба өдөр бүр аймгийн мал эмнэлгийн газарт мэдээ өгч ажиллаж байна.

Шаамар сум:

Шаамар сумын төмс, хүнсний ногооны хураалтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй дууссан.

Үүний дагуу сумын байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар хамтран Орхон чулуут сав газрын захиргаатай мэдээлэл судалгаа тооллогын ажлыг хийж гүйцэтгэн сумын хэмжээнд нийт:

- 6 булаг шанд,
- 6 гол горхи,
- өрөмдмөл худаг 21,
- цооног 2,
- рашаан 1,
- ус түгээх байр 7 тус тус бүртгэгдлээ.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны 10-р сарын 18-ны өдөр 9-12 дугаар ангийн 84 сурагч, 8 багш 300 ширхэг жимсний мод суулгалаа. Бүх нийтээр мод тарих өдрүүдэд идэвхтэй оролцож, мод, бут, сөөг, цэцэг тарьж цаашид иргэдэд уриалан ажиллалаа.

- Төмөр замын 34-р точкад нийт 200 ширхэг тарьц суулгац модыг тарьж суулгасан.
- Шаамар 6 км "Түрээсийн хүлэмж" байрлуулсан талбайд нийт 1410 ширхэг тарьц суулгац мод бутыг мөн суулгасан.
- Сумын хэмжээнд Дэлгэрхаан 1-р баг, Охиндий 2-р баг 1910 ширхэг, 3-р багт 1375 ширхэг, нийт 3285 ширхэг тарьц суулгац мод бутыг тарьж суулгасан.

Сумын Засаг даргын ивээл дор уламжлал болгон зохион байгуулдаг "Ахмадаа хүндэтгэе" арга хэмжээг зохион байгуулж 140 гаруй ахмад настныг хамрууллаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР